

11 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар****Төрийн үйлчилгээний чиглэлээр:**

Төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд ХШҮ хийж зөвлөн тусалж ажилласан. Бүх төсөвт байгууллагуудаас жилийн эцсийн ажлын тайланг гаргаж ирүүлэхэд аймгийн Засаг даргын 2021/06/10ны өдрийн А/343 тоот захирамжаар батлагдсан журмын дагуу ХШҮ хийж ирүүлэх чиглэлийг сумын Засаг даргын тоотоор хүргүүлж ажилласан. 11 сарын 12 нд Сумдын 2021 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд ХШҮ хийх ажлын хэсэг ирж удирдамжийн дагуу 11 үзүүлэлтээр гаргасан тайлангуудын нэгтгэлийг үзэж бүх мэргэжилтнүүд байгууллагын дарга нартай уулзаж тайлангаас тодруулга тайлбарыг авч мэргэжил арга зүйн зөвөлгөөг өгч ажилласан. Аймгийн ЗДТГ, Мерит төсөлтэй хамтран ISO9001:2015 зөвлөх багш Б.Энхнавч ирж 1 өдрийн сургалтыг хийсэн. Нийт 27 төрийн албан хаагч хамрагдсан. Аймгийн шуурхай штаб,ЭМГ,ОБГ-ын хамтарсан ажлын хэсгийн шалгалт 1 өдөр ирж сумын шуурхай штабын үйл ажиллагаа болон эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа дархлаажуулалтын 3-р тунгийн явцад шалгалт хийж арга зүйн зөвлөмж өгч ажилласан.Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системд албан тушаал албан хаагчийн хөдөлгөөнийг хийсэн ба нийт 5 төсөвт байгууллагын 165 албан хаагчийг нэгдсэн программд оруулаад байна. ЗДТГ-ын гадна талын болон дотор талын 10 өрөө тасалгааг монгол бичгийн хаягтай болгосон. Ил тод байдлыг хангах самбарыг шинэчилсэн мөн төрийн албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах чиглэлээр өрөө тасалгаанд хөшиг, хогын сав, өнгөт принтер, гэрэл шинэчлэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэсэн. ТГ-ын төсвөөс 5,0 сая төгрөгийг зарцуулсан.

Хүүхэд залуучууд гэр бүлийн чиглэлээр:

Гэр бүлийн хүчирхийллийн судалгааг гаргаж аймаг явуулсан

Ковид-19-н үед бүтэн болон хагас өнчин болсон хүүхдийн мэдээллийг аймгийн “Хүүхдийн төлөө газарт” өгсөн.

Хамтарсан багийн кейстэй иргэн аймгийн хамгаалах байрнаас ирэхэд нь хүлээж авч уулзаж гэрт нь хүргэж өгсөн.

ХАӨМС дээр МСҮТ-д суралцаж буй хүүхдийн мэдээлэлд тулгалт хийж алдаатай мэдээллийг Багийн засаг дарга нарт шүүж өгсөн

Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:

11 сарын 1-3-ны хооронд төсөвт байгууллагуудын 10 сарын гүйцэтгэлийг мэдээг хүлээн авч хянан баталгаажуулсан. Мөн 11 сарын1-20 хооронд аж ахуйн нэгж болон хувиараа хөдөлмөр эрхлэгчийн судалгааг авч хамруулсан бөгөөд нийт 63 аж ахуйн нэгж, 32 хувиараа хөдөлмөр эрхлэгч тооллогонд 100 хувийн ирцтэй хамрагдсан байна. 11 сарын 22,24 орон нутгийн хөгжилийн сан тогтвортой амжиргаа төслөөс зохион байгуулсан сургалт, Мерит төслөөс зохион байгуулсан ISO стандарт хэрэгжүүлэх сургалтуудад хамрагдсан. 11 сарын 25-30 ны хооронд төсөвт байгууллагуудын сарын эцсийн цалин хөлс тогтмол зардал болон бусад гүйлгээг хавсаргасан баримтыг үндэслэн хийж гүйцэтгэлээ.

Гурав: Нийгмийн бодлогын хүрээнд

ЕБС:11 дүгээр сарын 1нээс эхлэн хичээл сургалтын үйл ажиллагаа танхимын хэлбэрт шилжин хэвийн явагдаж байна. Сумын Засаг даргын 01/239 захирамжийн дагуу Ковид-19 халдвар тархалт нэмэгдэж буйтай холбогдон нийт багш, ажилчдын 74% нь 3-р тунд

хамрагдаад байна. 11 дүгээр сарын эхний 7 хоногоос эхлэн Орчин цагийн боловсролын салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан Тэргүүлэх зэрэгтэй, Заах аргач зэрэгтэй, Залуу багш нарын манлайлал, Удирдах ажилтан-7 хоногийн нэрэмжит аяныг тус тус зохион байгуулж. Уг арга хэмжээнд багш ажилчид өөрийн мэргэжлээ сурталчилах мөн эцэг эх, сурагч, ажилчдыг хамруулсан арга хэмжээ зохион байгуулагдаж байна. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Нийгмийн бодлогын хорооны жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2021 онд хийсэн ажлын тайланг тайлагнав.

Ил тод нээлттэй байгууллага байхын тулд 360.000 төгрөгийн зардлыг гарган ил тод байдлын мэдээллийн самбартай болсон. ERP e-mongolia.mn буюу Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд байгууллагын багш ажилтан 91 хүнийг нэвтрүүлсэн.

Мөнххаан сумын Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөл, Сумын ЗД, ЗДТГ, сумын ИТХ-ийн санал санаачилга, хамтын ажиллагааны үр шимээр тус сургуульд ХБНГУ-ын Монгол дахь ЭСЯ, Швейцарийн Хөгжлийн агентлагын санхүүгийн дэмжлэгтэйгээр "Мишээл хүүхдийн сан" ОУ-ын байгууллага 10 сарын 26-29-ны өдрүүдэд ЕБС-ийн 6-18 насны сурагчдын шүдний эмгэгийг эмчлэх, зөвлөгөө зөвлөмж, мэдээлэл өгөх ажлыг сэтгэл ханамжтай хийж хамтарч ажилласан. Нийт үзлэг эмчилгээнд 577 суралцагч буюу ЕБС-ийн нийт сурагчдын 58% нь шүдний эмчилгээ, үйлчилгээнд, танхимын сургалттай байсан 461 суралцагч амны хөндий, шүдний эрүүл мэнд, арчилгааны талаарх сургалтанд хамрагдлаа.

Хүүхдийн цэцэрлэг: Байгууллагын аюулгүй байдлыг хангах үүднээс гадна орчинд 4 ширхэг, дотор 16 ширхэг нийт 20 хяналтын камерыг аймгийн хөрөнгө оруулалт 5,0 сая төгрөгийн санхүүжилтээр бүрэн байршууллаа.

Боловсрол шинжлэх ухааны яам боловсролын хүрээлэнгээс **“БОЛОВСРОЛ -100”** тэмдэглэлт өдрийн үйл ажиллагааны хүрээнд СӨБ – ийн бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд улс орон даяар зохион явуулсан **“Эрдэм сурахын ач тус”** сэдэвт үйл ажиллагааг 4 бэлтгэл бүлгийн 93 хүүхдэд зохион явууллаа.

“Дархлаажуулалтын сарын аян” - ны хүрээнд байгууллагын нэмэлт 3 – р тунгийн вакцинд хамрагдах ёстой нийт 39 багш ажилчдаас 36 хүн нь бүрэн хамрагдаж вакцины хамрагдалт 92% - д хүрлээ. Олон улсын **ЭКО** сургууль, цэцэрлэг хөтөлбөрт хамрагдах хүсэлтээ илгээж албан ёсоор бүртгэгдлээ. Ингэснээр тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх ажилд өөрсдийн хувь нэмрээ оруулан хамтран ажиллаж боломжийг бүрдүүллээ. Соёлын төв, Залуучуудын холбооноос **“Улс тунхагласны баяр”**-т зориулан зохион явуулсан спорт танин мэдэхүйн тэмцээнд байгууллагаарааамжилттай оролцож **Волейбол, АХА** тэмцээнүүдэдТэргүүн байр эзэллээ. Боловсролын хүрээлэнгээс 54 дэх удаагийн эрдэм шинжилгээний хурлыг 2021-2022 оны хичээлийн жилд **“БАГШ НАРЫН МЭРГЭЖЛИЙН ӨСӨЛТӨД АХМАД БАГШ НАРЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ”** сэдэвтэйгээр зарлагдсан. Энэ удаагийн эрдэм шинжилгээний хурлын зорилго нь боловсролд тулгарч буй асуудал, түүнийг шийдвэрлэсэн арга туршлагыг эрдэм шинжилгээний бүтээлээр харилцан хуваалцах, багшийн судалгаа шинжилгээ хийх чадварыг дэмжих, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх сургуулийн менежментийг хөгжүүлэх туршлагыг түгээн дэлгэрүүлэх юм. Энэхүү үйл ажиллагааны 1-р шатыг байгууллага дээрээ зохион байгуулж, багш нар ганцаарчилсан

болон багийн түвшинд оролцож, 2-р шатанд оролцох илтгэлийг хэлэлцэж шалгарууллаа. 2-р шатанд оролцох илтгэлээр багш П.Оюунтуяа, Д.Дэлгэржаргал, Т.Давааням нарын **“Залуу багш нарын сурган хүмүүжүүлэх ур чадварыг хөгжүүлэхэд ахмад багш нарын оролцоо”** сэдэвт илтгэл шалгарлаа. Монгол бахархлын өдрөөр хамт олноороо **“Угийн бичиг хөтлөх арга зүй”**- н цахим сургалтанд хамрагдлаа. Сургалтанд нийт хамт олны 82% нь хамрагдсан.

Коронавируст (КОВИД-19) халдвар болон агаар дуслын замаар дамжих ханиад томуу, томуу төст өвчин, бусад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх уламжлалт анагаах ухааны хамар угаах заслыг хэрхэн хийх тухай мэдээллийг байгууллагын болон бүх бүлгүүдийн цахим хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд хүргэлээ.

Соёл: Сумын Засаг даргатай соёл урлагын арга хэмжээ зохион байгуулах хариуцлагын гэрээг байгуулан ажиллаж байна. Соёл урлагийн үйл ажиллагаа 5 удаа, сургалт арга хэмжээ 3 нийт 8 үйл ажиллагаанд 310 насанд хүрэгчид 570 хүүхэд үйлчлүүлсэн байна. Номын сангаар уншлаганд 96 ном гарч уншигчийн тоо 45 байна Угсаатны зүйн музейтэй хамтарч нандин өв үзэсгэлэнг зохион байгуулсан. Мөн аймгийн нийтийн цэнгээнт бүжгийн холбоотой хамтран бүжгийн сургалтыг 10 хоног зохион байгуулж нийт 46 иргэн хамрагдсан. Улс тунхагласны баярт зориулан спорт урлагын арга хэмжээг зохион байгуулсан.

Эрүүл мэндийн чиглэлээр:

2021 оны 11 сарын 30-ны байдлаар 54 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Үүний 43 насанд хүрэгчид, 9 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн. Үүнээс Коронавирусийн халдвараар хэвтэн эмчлүүлсэн 29 хүн байна. Хүнд хүндэвтэр 5 хүн АНЭ-т шилжүүлсэн.

Урьдчилан сэргийлэх үзлэг 135 байна. Ковид - 19 вакцины 1,2,3 тунг өдөр бүр хийж мэдээг ЭМГазар болон бусад газарт мэдээлж байна. Нийт 3082 хүн вакцинд хамрагдахаас 3-р тунд 947 хүн хамрагдаж нийт хамрагдалт 30,7 хувь байна. Комирнэти вакцинд зорилтот бүлгийн 64 хүн хамрагдаад байна.

Ковид19 цар тахалтай холбоотой мэдээлэл сургалт сурталчилгааг зорилтот бүлэгт болон цахимаар иргэдэд мэдээллийг хүргэж байна.

ЭМТөвийн нэг удаагийн эм эмнэлгийн хэрэгслийн орлого зарлагыг burtgel.mn программд шивж мэдээллийг оруулж байна.

Түргэн тусламжийн дуудлага 46 ирснээс алсын дуудлага – 12, ойрын дуудлага 34 ирсэн байна. Дуудлагыг цаг тухай бүрд нь барагдуулсан.

Дөрөв: Мал эмнэлэгийн болон ХХАА-н чиглэлээр:

Мал эмнэлгийн тасаг адууны мах 36490, үхрийн мах 146827, хонины мах 113194, ямааны мах 49812, тэмээний мах 2150 нийт 348473 кг махны баталгаажуулалтыг хийсэн.

Тав : Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр:

Нэг. Хүрээлэн буй орчин байгалийн гамшгийн талаар Баянтэрэм 1-р багийн нутаг болох “Ширдэгт” хэмээх газар 2021 оны 11 сарын 04-ны өдөр хээрийн түймэр гарч 2 машин, 20 хүн ажилласан. Үүнд нийт 678920 төгрөгний зардал гарсан. Айлын гаднах үнс нурамнаас гарсан тогтоогдож эзэн холбогдогч нь хохирлыг барагдуулсан болно. Түймрийн материалыг

аймгийн онцгой байдлын газар болон цагдаагийн газарт хүргүүлсэн. Сүхбаатар аймгийн усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох ажлын хэсгийн уулзалт хэлэлцүүлэгт Иргэдийн төлөөлөгчийн хурлын дарга, Байгаль хамгаалагч нар оролцсон. “Цагаан булгийн эх хашсан”-ыг аймгийн ажлын хэсэг 3 хүний бүрэлдэхүүнтэй ирж хүлээж авсан. 248 иргэнд газар өмчлөлийн захирамжаар газар олгосон. 8 нэгж талбарт дуудлага худалдаа зардаж 2021 оны төлөвлөгөөний биелэлт хэрэгжиж 2022 оны төлөвлөгөөний төслийн бэлтгэл ажлыг хийж байна.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ТГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

О.ТУЯА.